



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ СУРГУУЛЬ



ОЛОН УЛСЫН
ХАРИЛЦАА

WORLD AFFAIRS

2004 № 2

256 (09)



Улаанбаатар хот

Тус сэтгүүл нь анх 1996 оноос "Алтан аргамж" нэрээр, 2002 оноос "Олон улсын харилцаа" нэрээр гарч байна.

The journal has been published since 1996 as "Altan argamj" and since 2002 as "World Affairs"

Сэтгүүлийн зөвлөл:

Editorial Board:

Эрхлэгч:

Editor in Chief:

Н.Алтанцэцэг (проф.доктор Ph.D)

N.Altantsetseg
(Prof.Ph.D)

Нарийн бичгийн дарга:

Assistant Editor:

Д.Тунгалаг (дэд проф.доктор Ph.D)

D.Tungalag (Prof.Ph.D)

Гишүүд:

Members:

Ж.Баясах (тэр.проф.доктор Ph.D)
Ц.Гүрбадам (проф.доктор Sc.D)
Д.Цолмон (тэр.проф.доктор Ph.D)
С.Отгонбаатар (дэд проф.доктор Ph.D)
Ж.Бор (проф.доктор Ph.D)
Л.Даваадэлгэр Ахлах багш

J.Bayasakh (Prof.Ph.D)
Ts.Gurbadam (Prof.Ph.D)
D.Tsolmon (Prof.Ph.D)
S.Otgonbaatar (Prof.Ph.D)
J.Borr (Prof.Ph.D)
L.Davaadelger Senior Lecturer

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Typist:

С.Энхцэцэг

S.Enkhtsetseg

Сэтгүүлийн хаяг:

Editorial Address:

МУИС-ийн Олон улсын
харилцааны сургууль
Шуудангийн салбар – 46 а, хайрцаг-6
Улаанбаатар, Монгол улс
Утас: 311809; 318640; 328623
Факс: (976-11)319245
E-mail: admin_sfs@mongol.net

School of Foreign Service
Mongolian National University
P.O. – 46 a, Box-6
Ulaanbaatar, Mongolia
Tel: 311809; 318640; 328623
Fax: (976-11) 319245
E-mail: admin_sfs@mongol.net

АГУУЛГА

I. Олон улсын аюулгүй байдал, харилцаа, соёл иргэншил

<i>Р.Давааням</i>	
Монгол улсын үндэсний аюулгүй байдалтай холбогдох зарим асуудал	3
<i>А.Түвшинтөгс</i>	
Зүүн хойд Азид аюулгүй байдлын олон талт механизм бүрэлдэх боломж ба Монгол улс	19
<i>Д.Бүдсүрэн</i>	
Зүүн хойд Азийн аюулгүй байдал ба хүчний тэнцвэрийн асуудал	36
<i>Г.Баасанхүү</i>	
Олон улсын харилцаан дахь соёл иргэншлийн асуудалд	49
<i>Г.Баасанхүү</i>	
Дэлхийн соёл иргэншлийг ангилах тухайд	62
<i>Д.Оюунсүрэн</i>	
Нэгдсэн үндэстний байгууллагын шинэчлэл	69

II. Олон улсын эдийн засгийн харилцаа

<i>Ц.Гурбадам, Б.Санжмятав</i>	
Гадаадын хөрөнгө оруулалтыг Монгол улсад татах бодлогын асуудалд	74
<i>Б.Мягмаржав</i>	
Олон улсын эдийн засгийн харилцаа: “Монголын нууц товчоо”-нд тусгалаа олсон нь	91
<i>Д.Намсрай, Д.Отгончимэг</i>	
Ядуурал, тэгш бус байдал-дэлхий нийтийн тулгамдсан асуудал	96
<i>Д.Отгончимэг, Б.Санжмятав</i>	
Зүүн хойд Ази дахь эрчим хүчний хамтын ажиллагаа	108
<i>Н.Содномцог</i>	
Олон улсын худалдаа	119
<i>Д.Тунгалаг</i>	
Олон улсын хөдөлмөрийн статистик	126
<i>Б.Мягмаржав</i>	
Африкийн нүүдлийн мал аж ахуйн хөгжлийн үндсэн асуудал	140

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБОГДОХ ЗАРИМ АСУУДАЛ

Р.Давааням*

Олон улсын эрх зүйн талаас нь авч үзвэл “Үндэсний эрх ашиг” хэмээх ойлголтыг олон янзаар тодорхойлсон байдаг боловч тэр нь улс болгонд тэр бүр таардаггүй нилээд бүдүүвчилсэн загвар юм. Аливаа улс аюулгүй байдал, үндэснийхээ эрх ашгийг дараах арга зам, хэрэгслүүдээр дамжуулан хангаж ирсэн. Үүнд:

-хөгжингүй эдийн засаг;

-ухаалаг уян хатан гадаад бодлого;

-батлан хамгаалах зохих чадвар зэрэг болно.

Харин эдийн засаг, цэрэг зэвсгийн чадавхи багатай бага буурай орон тэр дундаа Монгол улсын хувьд уян хатан ухаалаг гадаад бодлогыг үр бүтээлтэй оновчтой, ашиглах арга зам үлдэж байна. Үүнээс харахад Монгол улсын аюулгүй байдлаа хангахад гадаад бодлого ямар чухал ач холбогдолтой нь харагдаж байна. Гадаад бодлогын ач холбогдлыг нэмэгдүүлж байгаа өөр нэг хүчин зүйл нь Монгол улсын хувьд газар зүйн байршил юм. Эдийн засаг, цэрэг, зэвсгийн хувьд хүчирхэг, цөмийн зэвсэгтэй, дэлхийд нөлөө бүхий хоёр их гүрний дунд оршдог, далайд гарцгүй, дэд бүтэц сул хөгжсөн, гадаад ертөнцтэй харилцахад болон үндэсний гол стратегийн бүтээгдэхүүнүүдийн хувьд хоёр гүрнээс бодит хамааралтай зэрэг онцлог байдал нь гадаад бодлогын гүйцэтгэх үндсэн үүргийг тодорхойлж байна. Өөрөөр хэлбэл эдгээр хоёр их гүрний ашиг сонирхлоос Монгол улсын үндэсний эрх ашиг тодорхой хэмжээгээр шалтгаалж ирсэн бөгөөд цаашид ч харгалзаж үзэлгүй орхиж боломгүй хүчин зүйл хэвээр байх болно.

Аливаа улс үндэстэн өөрийн онцлогийг хичнээн сайн ухаарна төдий чинээгээр үндэснийхээ эрх ашгийг зөв тодорхойлон, олон улсын тавцанд ухаалаг бодлого явуулж чадна. Өөрөөр хэлбэл үндэсний онцлогоос, үндэсний эрх ашиг

* ШУА, ФСЭХ, УТС Секторын эрдэм шинжилгээний ажилтан

төрж, түүнээс үндэснийхээ аюулгүй байдлыг хангах гэдэг асуудал урган гардаг зүй тогтолтой.

Монгол улс үндэснийхээ аюулгүй байдлыг хангахад гадаад улсууд дахь нэр хүнд; үндэсний эв нэгдэл, нягтрал; улс төрийн тусгаар тогтнолоо бэхжүүлэх ардчилсан тогтолцоог боловсронгуй болгох; эдийн засгийн хараат бус байдал бий болгох, хамгаалах, хангах, сахих; өөрийн өвөрмөц соёл иргэншлийн өвийг сахин хамгаалах, авч үлдэх зэрэг асуудлуудыг нэн түрүүнд анхаарлын төвд байлгах шаардлагатай байна.

Бидний хувьд үндэсний аюулгүй байдлаа хангах хоёр дахь аргыг сонгож байгаа. Өөрөөр хэлбэл эдийн засаг, хүн ам, нөөц маань биднийг цэрэг зэвсгийн хувьд хүчирхэг байх боломж олгохгүй байгаа болохоор тусгаар тогтнол, эрх чөлөө, аюулгүй байдлаа дипломат аргаар хангахаас өөр аргагүй¹ юм.

Хоёрдахь арга замыг сонгох болсон дараагийн нэг шалтгаан нь геополитикийн хүчин зүйлээс үүдэлтэй. Өөрөөр хэлбэл дэлхийд нутаг дэвсгэрийн хэмжээгээр 1-р байранд ордог ОХУ, мөн шинэ зууны хүчирхэг гүрэн, хүн амын тоогоор дэлхийд тэргүүлдэг БНХАУ гэсэн хоёр их гүрний дунд оршиж буй Монгол улсыг эдийн засаг, улс төр болон бусад хүн ам зүйн зэрэг олон талаас нь авч үзвэл яах аргагүй жижиг улс юм. Монгол улс өнөөдөр дэлхийн хэмжээний хоёр их гүрний дунд оршдогоос гадна бүс нутгийн хэмжээнд АСЕАН, ЕХ гэх мэт тогтвортой хамтын ажиллагааны байгууллагууд үүсэх нөхцөл хараахан бүрэлдээгүй улс төрийн ээдрээтэй бүс нутагт оршин тогтнож байна. Мөн дэлхийн эдийн засгийн томоохон төвүүд харьцангуй алслагдмал байрлалтай, хөгжсөн Япон, үсрэнгүй хөгжиж буй Хятад, Өмнөд Солонгос зэрэг орнуудын хооронд тогтвортой эдийн засгийн хамтын ажиллагааны бүсчилсэн байгууллага хараахан үүсээгүй нөхцөл байдал нь Монгол улсын эдийн засгийн гадаад орчинд нөлөөлж байна. Аливаа улсын гадаад бодлого, аюулгүй байдал нь оршин буй газар зүйгээр тодорхойлогдоно гэж Наполеон Бонапарт хэлсэн нь Монгол улс шиг жижиг газар зүйн онцлогтой улсад ихээхэн хамааралтай² юм.

Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангах гол аргын нэг нь түүнд нөлөөлөх хүчин зүйлсүүдийг сайтар судалж, танин мэдэх явдал юм. Чухамдаа

¹ Ж.Бор. Монголын тусгаар тогтнолын гэрэл сүүдэр. УБ., 1996. 78 дахь тал

² Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба гуравдагч түши орнууд: Өнөө ба ирээдүй. УБ., 13 дах тал

Монгол улсын аюулгүй байдалд нөлөөлөх дотоод (улсын, бүсийн, аймаг-нийслэлийн, сум, орон нутгийн), гадаад (дэлхийн, бүс нутгийн, салбар бүс нутгийн), объектив, субъектив, гэнэтийн, тодорхой хугацааны, түүхэн нэгэн үеийн, мөнхийн, бодит болон болзошгүй³ хүчин зүйлүүд нь юу вэ? гэдгийг нарийн тодорхой тооцоолсны үндсэн дээр нийгэм, улс төр, зохион байгуулалт, эдийн засаг, дипломат, цэрэг, тагнуул, хууль зүйн аргаар дангаар буюу олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлснээр аюулгүй байдлаа хангах⁴ явдал юм.

Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг оршин тогтнохын, нийгэм, төрийн байгууллын, иргэдийн эрх, эрх чөлөөний, эдийн засгийн, шинжлэх ухаан, технологийн, мэдээллийн, монгол соёл иргэншлийн, хүн ам, удмын сангийн, экологийн аюулгүй байдал⁵ гэж тус тус ангилаж тухай бүрийн хангагдсан байдалд үнэлэлт өгөхийг хичээе.

Монгол улсын оршин тогтнохын аюулгүй байдал: Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал хангагдсаныг хэлнэ⁶ гэж тодорхойлсон байдаг. Монгол улс хөрш хоёр улстай хил хязгаар тогтоох асуудлаар маргаантай асуудал байхгүй, энэхүү асуудлыг амжилттай шийдвэрлэж чадсан нь томоохон амжилт гэдгийг хэлэх хэрэгтэй ч улсын хилийг хууль бусаар нэвтрэх, хил дамнасан хууль бус наймаа хийх зөрчил гаргах явдал элбэг байна. Энэ нь хоёр хөрш их гүрний аль алиных нь иргэдийн зүгээс гарч байгаа зөрчил юм. Хууль бусаар хил нэвтрэх, хилийн зөрчил гаргах явдалтай тэмцэх нь Орос, Хятад, Монгол улсын хооронд шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Нийгэм, төрийн байгууллын аюулгүй байдал: Монгол улсын үндсэн хуулиар бататгасан төр, нийгэм, эдийн засгийн тогтолцоо, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмууд, түүнчлэн хүний эрх, эрх чөлөө баталгаажсан байдлыг хэлнэ⁷ гэж заасан байдаг. Нийгэм, төрийн аюулгүй байдал нь гадаад, дотоод хүчин зүйлүүдийн харилцан нөлөөлөлд оршдог.

Өнөөдрийн даяаршлын эрин үед бага буурай, хөгжиж буй улсуудад гаднаас үзүүлэх нөлөөлөл их байна. Түүний нэг илрэл нь хөгжингүй, хөгжиж буй

³ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 1994. 2-р бүлэг, 7-р зүйл

⁴ Мөн тэнд 3-р бүлэг, 10-р зүйл

⁵ Мөн тэнд 1-р бүлэг зүйл, 1-9

⁶ Мөн тэнд 2-р зүйл

⁷ Мөн тэнд 3-р зүйл

хүчирхэг улс орнууд, олон улсын томоохон байгууллагууд (Олон улсын валютын сан", "Дэлхийн банк)-ын зүгээс үзүүлж буй шахалт, нөлөөлөл нь түүний дотоод дахь шийдвэр гаргалтад ихээхэн нөлөөтэй байгаагаар тайлбарлагдана.

Бага буурай, хөгжиж байгаа орнууд гадаад хүчин зүйлүүдээс хамааралтай байгаагийн гол шалтгаан нь тухайн орнууд улс төр, эдийн засгийн хүчин чадал сул байгаатай холбоотой. Үүний гол шалтгаан нь үндэсний эдийн засгийн хувьд өөрөө өөрийгөө тэтгээд явах боломж муутай байх, улс төрийн хувьд тогтворгүй, экспорт, импорт, зээл тусламжаас шууд хамраалтай байх явдал юм. Өөрөөр хэлбэл экспортын цөөхөн төрлийн барааг бэлтгэж гаргадаг, харин импортоор хэрэгцээт дийлэнх бараагаа авдгаас экспорт, импортын ихээхэн зөрүү гардаг, тэрхүү зөрүүг зээл, тусламжаар нөхдөг, харин түүнийг авахын тулд бусдын болзол, нөхцлийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болдог, зээлийн болон хүүгийн дарамтад орох зэрэг нь тухайн улсын бүрэн эрх, халдашгүй байдалд шууд нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл тухайн улсын дотоод нилээдгүй бодлогод донор олон улсын байгууллагууд, орнууд тодорхой хэмжээгээр нөлөөлж өөрийн сонирхлыг тусгуулах боломжтой, зарим асуудал дээр тусгуулсаар байна.

Нөгөөтэйгүүр дотоод хүчин зүйл буюу төрийн тогтвортой байдал, УИХ болон орон нутгийн сонгууль хуулийн дагуу явагдах, ард түмний амьдралын түвшингийн өсөлт, ардчилал, нийгэмд шударга ёс, тэгш эрх хангагдах гэх мэт нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж буй арга, хэлбэр, бодлого, үйл ажиллагаа нь төрийн тогтвортой байдлыг хангахад ихээхэн нөлөөтэй. Эдгээр асуудлыг зөв шийдвэрлэж чадаагүйгээс авилгал, хээл хахууль, өсөх, албан тушаалаа урвуулан ашиглах, баялгийг шудрага бус хуваарилах зэрэг сөрөг үзэгдэл өсөх газар авах хандлагатай болж олон нийтийн бухимдлыг төрүүлж байна. Монгол улсад авилгал, хээл хахуулийн асуудлаар явуулсан олон судалгаа нь өнөөдөр энэ асуудал төрийн тогтвортой байдал, оршин тогтноход бодитой нөлөөлөхүйц түвшинд хүрээд байгааг харуулж байна. Тухайлбал: 1999 оны VI-VII саруудад "Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн" хүрээнд хийсэн судалгаагаар оролцогчдын 49.6 хувь нь авилгал Монголд газар авсан гэж үзсэн бол 2000 оны III сард Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим болон Зах Зээл Судлалын Хүрээлэнгээс хамтран явуулсан судалгааны таны бодлоор аль нь авилгалд хамгийн өртөмхий салбар тодруулах судалгаанд 1 гааль, 2 шүүх, 3

татвар, 4 цагдаа, 5 банк, 6 боловсрол, 7 төр захиргааны байгууллагууд гэсэн дарааллаар улс орны хөгжилд шийдвэрлэх нөлөө бүхий салбаруудыг дурьдсан байна.

Ер нь манай улс олон улсад хэрэглэж мөрддөг авилгал судлалын индексээр 4.3 оноо авч 43-р байр эзэлсэн. Албан тушаал, хээл хахуультай холбоотой гэмт хэрэг 1991-1995 онд 389, 1996-2000 онд 1030-д хүрч даруй 2.6 дахин өссөн байна. Өнөөдөр энэ төрлийн гэмт хэргийн гаралт улам ихсэж төрийн томоохон албан тушаалтан ч холбогдох боллоо. Гэхдээ энэ нь бас илрүүлэлт сайжирч, тэмцэл үр дүнгээ өгч байгаатай бас холбоотой. Манай улс дахь авилгалын асуудал нь улс орны тогвортой байдалд нөлөөлөөд зогсохгүй цаашлаад олон улсын нэр хүндэд ч нөлөөлж байна. Үүний илрэл нь 2001 оны V сарын 28-31-нд уг асуудлаар Голландын Хааг хотноо болсон олон улсын хурал дээр авилгалд ихээр өртсөн улс, орнуудын тоонд Монгол улсын нэрийг оруулсан нь манай орны гадаад нэр хүндэд нөлөөлөх, түнш орнуудын харилцаанд эргэлзээ төрүүлэх байдалд хүргэж болзошгүйг анхаарууштай.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс 173 орныг хамран гаргасан судалгаагаар Монгол улс 113 дугаарт буюу хүний хөгжлийг дунд зэргээр хангасан гэдэг ангилалд орж, авилгалын асуудлаар авилгал гарах нөхцөл багатай орны тоонд оруулсан байна. Энэ нь хэдий сайн ч АНУ-д төвтэй “Олон улсын ил тод байдлын хүрээлэн” -ээс саявтархан явуулсан “Авилгал хахуулийн 2004 оны индекс” хэмээх судалгаанд Монгол Улс 84-р байранд буюу үлэмж итгэлгүй гэсэн байрыг эзэлсэн байна.

Хээл хахуулийн эсрэг олон арга хэмжээнүүдийг авч, үйл ажиллагаа зохион байгуулж байна. Гэвч тодорхой үр дүнд хүрэхгүй байна. Гэмт хэрэг зохион байгуулалтын шинжтэй болж, ажилгүйдэл, ядуурал өсөж, хүмүүсийн амьдралын түвшин буурч, олон нийтийн дунд бухимдал газар авч, төр засагт итгэх иргэдийн итгэл алдарч, улс төрийн болон нийгмийн асуудлыг шийдвэрлэхийг зорилгоо болгосон олон хөдөлгөөн, жагсаал, цуглаан газар авч (улс төрийн тодорхой зорилго дэвшүүлж буй Эрүүл нийгмийн төлөөх, Эрс шинэчлэл, байгаль орчин баялгийн тэгш бус хуваарилахтай холбогдох Миний газар шороо, Хөгжлийн төлөөх хөдөлгөөн мөн тэтгэврээ нэмүүлэхийг хүсч буй ахмадын, төлбөр болон

оюутны байрны асуудлаар хийсэн оюутнуудын гэх мэт) байгаа нь төрөөс явуулж буй бодлогод иргэд, олон нийт сэтгэл хангалуун бус байгааг харуулж байна.

Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал: Бие хүн өөрийн хийгээд эх орон, ард түмнийхээ ашиг сонирхлын төлөө биеийн болон оюуны хүч чадавхиа бүрэн зориулах, олон улсын гэрээний дагуу хүний эрхийн асуудлаар Монгол улсын хүлээсэн үүрэг хэрэгжих нөхцөл бүрдсэн байдлыг хэлнэ⁸ гэж заасан байдаг.

Хэдийгээр иргэдийн эрх, эрх чөлөө ерөөсөө зөрчигдөхгүй байна гэж хэлэхгүй ч Монгол улсын хувьд бусад өөрчлөлт хийж байгаа улсуудыг бодвол иргэдийн улс төрийн болон эдийн засгийн эрх, эрх чөлөө нийгмийн болон бусад бодит баталгаагаар харьцангуйгаар сайн хангагдаж чадсан гэдэгтэй олон хүн санал нийлдэг ч энэ байдал нь хангалттай хэмжээнд хүрчихсэн гэж үзэх түвшинд хүрээгүй байна. Үүний гол шалтгаан нь өнөөдөр ард нийт өөрийн төлөөллөөр дамжуулан төрийн эрх барихад оролцдог гэж ярьж, хэлж байгаа ч хэрхэн ямар замаар яаж оролцох нь төдийлөн тодорхой бус, өөрөөр хэлбэл хууль батлах үйл ажиллагаа нь иргэдийн оролцооноос илүүтэй гадаадын хуулийг хуулбарлахыг урьтал болгодог арьдралд нийцгүй хууль ихээр батлагдаж байна.

Иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөө сайн хангагдсан гэдэгтэй судлаачид санал нийлдэг ч тэдний аюулгүй оршин байхын эрх, эрх чөлөөг зөрчин гарсаар байгаа гэмт хэргийн асуудлыг энд дурьдахгүй өнгөрч болохгүй. 2005 оны эхний 9 сарын байдлаар 12001 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 10.1 хувь нь эмэгтэй, 8.2 хувь нь хүүхэд, 66.4 хувь нь 18-35, 25.4 хувь нь 36-аас дээш насны хүмүүс байгаагийн 20.1 хувь нь ажилчин, малчин, 5.5 хувийг албан хаагч, 4.9 хувийг оюутан, сурагч, 68.5 хувийг ажилгүй хүмүүс эзэлж байна. Гэмт хэрэгт холбогдогчдын 22.8 хувь нь согтуугаар, 23.1 хувь нь бүлэглэн иргэдийн эрх чөлөө, амар тайван байдлыг алдагдуулсан гэмт хэрэг өдүүлсэн. Гэмт хэргийн улмаас 1493 хүн нас барж, 4472 хүн хүнд, хөнгөн байдлаар гэмтсэн. Нийт гэмт хэрэг тоон үзүүлэлтээр буурч байгаа ч онц хүнд, хүнд гэмт хэрэг жил дараалан өссөн зэрэг олон тоо баримтыг дурьдаж болно. Энэ бүхэн иргэдийн аюулгүй оршин байх эрх, эрх чөлөөг зөрчин гарч байгааг анхаарах нь зүйтэй.

Мөн төр засаг иргэдийн харилцаа, харилцан үйлчлэл алдагдсан. Иргэд эрх зүйн мэдлэг муу, төр иргэндээ бус иргэд төрдөө үйлчлэх гаж тогтолцоо руу хазайх

⁸ Мөн тэнд, 4-р зүйл

шинж сүүлийн үед илүүтэйгээр анзаарагдах болсон. Үүнээс гадна төрийн үйл ажиллагааны тухайд эрх мэдэл хуваарилалт, түүнд тавих хөндлөнгийн хяналтын харилцаа алдагдсан, төрийн байгууллагууд иргэдийн өмнө хаалттай хэвээр байгаа зэрэг олон хүчин зүйлүүдийг дурьдаж болно.

Эдийн засгийн аюулгүй байдал: Дотоод нөөц бололцоогоо ашиглан нөхөн үйлдвэрлэл явуулах, ард түмнийхээ хэрэгцээг хангах, тусгаар тогтносон байдлаа бэхжүүлэх эдийн засгийн чадавхитай байх, шаардлагатай нөхцөлд улс орноо тодорхой хугацаагаар тэтгэж чадах эдийн засгийн бүтэц бүрдсэн байхыг хэлнэ⁹ гэж тодорхойлсон байдаг. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын хамгийн эмзэг тал нь уг асуудал болж байна. Монгол улс эдийн засгийн хувьд дотоодын баталгаа байхгүй бөгөөд нэг тогтолцооноос нөгөө тогтолцоо руу шилжих явцад хүндрэл бэрхшээлтэй тулгаран, өөрийн боломжоор дотоодын эдийн засгийн хөгжлөө хангаж чадахгүй байсны улмаас ядуурал, үндэсний эдийн засгийн уналт зэрэг нь газар авчээ. Монголын эдийн засагт том орон зай эзэлж байсан Орос улсын бараа бүтээгдэхүүнээр хангагдаж байсан зах зээлийг Хятадын чанар муутай, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бараа бүтээгдэхүүн эзэлж, түүнээс үүдэлтэй хордлого болон бусад өвчин ихсэх боллоо.

Монгол улсын нийт барааны эргэлтэд ОХУ экспортын 33 хувь, импортын 13 хувь, гадаад худалдааны эргэлтийн 23 хувь, Хятад улс экспортын 57 хувь, импортын 13 хувь, гадаад худалдааны эргэлтийн 33.5 хувь тус тус эзлэж байна. Энэ баримт тус улсын гадаад харилцаанд хоёр хөршийн гүйцэтгэж байгаа жин, нөлөөг харуулж байна. Өнөөдөр БНХАУ 1.28 тэрбум хүн амтай, нэг хүнд ноогдох ДНБ 1100 ам. доллар, ОХУ нь 143 сая хүнтэй, нэг хүнд ноогдох ДНБ 2610 ам. доллар болоод байгаа бол манай орны хувьд 2.5 сая хүн амтай, нэг хүнд ноогдох ДНБ 480 ам. доллар байна.

Дэлхийн банкны саяхны судалгаанаас үзвэл нэг хүнд оногдох үндэсний нийт бүтээгдэхүүний үзүүлэлтээр жижигхэн Бахамын арлууд 14960, Кипр 12370 ам. доллар байхад Конго 570, Армени 520, харин манай оронд 420-470 ам долларт хэлбэлзэж байна. Жижиг орнуудын талаар явуулсан судалгаагаар (5 саяас доош хүн амтай) манай улсын нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүн 400 ам доллар гэж тэмдэглэгдэж нэн буурай хөгжилтэй Соломоны арлууд (620), Лесото

⁹ Мөн тэнд, 5-р зүйл

(580) зэрэг орноос доогуур орж байна. Хүн амын амьжиргааны түвшинг тогтоох 1998 оны судалгаагаар нийт хүн амын 35.6 хувь, хот суурин газрын хүн амын 39.4 хувь, хөдөөгийн хүн амын 32.6 хувь нь ядуу амьдарч байна гэсэн дүн гарсан байна. Энэ байдал нь улам бүр газар авч байна.

Дээрхээс харвал дотоодын үйлдвэрлэл сул хөгжсөн хүн амын дунд ядуурал газар авсан, эдийн засаг, улс төрийн хувьд хүчирхэг улсуудын дунд оршдог зэрэг байдал нь Монгол улсын эдийн засгийн салбарын эмзэг талыг харуулж байна. Өөрөөр хэлбэл 2004 оны байдлаар уул уурхайн салбар 30.8 хувь, хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн нийлүүлэлт малын тоо 2.5 саяар өссөн үзүүлэлттэй байгаа ч ДНБ-нд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний эзлэх хувийн жин Азидаа хамгийн доогуур буюу 7 хувиар буурчээ.

Монгол банкнаас гаргасан 2005 оны судалгаагаар Монгол улсад гадаадын шууд хөрөнгө оруулалт байнга тогтвортой өсч 1992-2004 оны хоорондох хугацаанд 73 улсаас 1.2 тэрбумд хүрсэн нь сайшаалттай зүйл хэдий ч 2004 онд орж ирсэн шууд хөрөнгө оруулалтын 62.3 хувь нь геологи, уул уурхай, олборлолтын салбарт хийгдсэн, олборлосон түүхий эдээс цөөн тооны нэр бүхий бүтээгдэхүүнд анхан шатны боловсруулалт хийж, үлдсэн түүхий эдээ шууд гаргаж байгаа нь гадаадын хөрөнгө оруулалт улс орны эдийн засгийн хөгжил, өсөлтөд бодитой нөлөөлж чадахгүй байна.

Нөгөө талаар нийт гадаадын хөрөнгө оруулалтын бүтцийг дотор нь задалж үзвэл БНХАУ 37.9 хувийн хөрөнгө оруулснаар тэргүүлж байна. Дээрх бүх тооноос харвал экспорт, импорт, гадаадаас оруулж буй хөрөнгө оруулалт зэрэг эдийн засгийн бүхий л гол хүчин зүйлээрээ манай улс нь БНХАУ-аас шууд хамааралтай болоод зогсохгүй үндэсний эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөхүйц хэмжээнд байна.

Дээрх баримтаас дүгнэвэл манай улсад үйлдвэрлэх салбар хөгжөөгүй, бусад орноос эдийн засгийн хувьд хамааралтай, өөрөө өөрийгөө тэтгээд явах чадавхгүй байгааг харж болно.

Өнөөдөр эдийн засгийн аюулгүй байдлын асуудал нь нэгэнт бүхний анхаарлын төвд тавигдаад байгаагийн нэг илрэл нь 2002 оны 6-р сард УИХ, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс хамтран зохион байгуулсан “Эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал” гэсэн сэдэвт бага хурал юм. Энэхүү бага хуралд

УИХ-ын Төсвийн байнгын хорооны дарга Н.Баяртсайханы “Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдлын тулгамдсан асуудлууд”, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга Т.Очирхүү, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, УИХ-ын гишүүн Н.Тогтох, Монгол банкны Ерөнхийлөгч О.Чулуунбат, Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдорж, ШУА-ын Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн захирал Г.Чулуунбаатар зэрэг олон эрдэмтэн, улс төрчид оролцож эдийн засгийн тулгамдсан асуудлаар өөрсдийн илтгэл тавин хэлэлцүүлж санал бодлоо солилцсон бөгөөд мөн “Эдийн засгийн хөгжил, аюулгүй байдлын асуудал”-аар олон нийтийн дунд явуулсан социологийн судалгааны дүн энэхүү асуудал хамгийн эмзэг анхаарал татсан асуудал болохыг мөн нотлож байна.

Товчоор дүгнэвэл улс төрчид, эрдэмтэд, олон нийтийн хувьд Монгол улсын эдийн засгийн хүчин чадал сул, гадаадаас, тэр дундаа нэг улсаас нэн хамааралтай байгаа бөгөөд цаашид энэ хэвээр байж үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлсөн хэвээр байна гэдэгтэй бүхий л түвшинд санал нийлж байгаа боловч энэхүү асуудал дээр тусгайлсан бодлого боловсруулах, үр дүнтэй хэрэгжүүлэх тал дээр хангаттай бус дутмаг байна.

Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал гэдэг нь өөрийн орны экологийн өвөрмөц нөхцөлд технологи болон мэдээлэл, судалгааг улс орныхоо хөгжилд ашиглах, шинжлэх ухааны үндэсний чадамжийг дээшлүүлэх, оюуны үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг хангасан нөхцөл байдал¹⁰ юм.

Мэдээллийн аюулгүй байдал гэдэг нь төрөөс улс орны дотоод, гадаад бодит байдлыг зөв үнэлж, оновчтой шийдвэр гаргах үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллээр төрийн байгууллага, ард иргэд хангагдсан, Монгол улсын талаар гадаад мэдээлэл тархах нөхцөл хангагдсан байдлыг хэлнэ¹¹ гэж тус тус тодорхойлсон.

Бид шинжлэх ухаан технологи, мэдээллийн аюулгүй байдлын ач холбогдлыг үзэхдээ гадаад болон дотоод гэсэн хоёр хэсэгт хувааж үзвэл үр дүнтэй байна. Монгол улс өөрчлөлт шинжлэлийг хийж эхлэх үед технологийн хувьд 100 хувь хуучнаар социалист чиг баримжаатай гэгдэж тэр дундаа ЗХУ-аас (хуучнаар) хамааралтай явж ирсэн бөгөөд ЗХУ болон манай улс дотооддоо өөрчлөлт хийж

¹⁰ Мөн тэнд, 6-р зүйл

¹¹ Мөн тэнд, 7-р зүйл

УИХ-ын Төсвийн байнгын хорооны дарга Н.Баяртсайханы “Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдлын тулгамдсан асуудлууд”, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга Т.Очирхүү, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, УИХ-ын гишүүн Н.Тогтох, Монгол банкны Ерөнхийлөгч О.Чулуунбат, Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдорж, ШУА-ын Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн захирал Г.Чулуунбаатар зэрэг олон эрдэмтэн, улс төрчид оролцож эдийн засгийн тулгамдсан асуудлаар өөрсдийн илтгэл тавин хэлэлцүүлж санал бодлоо солилцсон бөгөөд мөн “Эдийн засгийн хөгжил, аюулгүй байдлын асуудал”-аар олон нийтийн дунд явуулсан социологийн судалгааны дүн энэхүү асуудал хамгийн эмзэг анхаарал татсан асуудал болохыг мөн нотлож байна.

Товчоор дүгнэвэл улс төрчид, эрдэмтэд, олон нийтийн хувьд Монгол улсын эдийн засгийн хүчин чадал сул, гадаадаас, тэр дундаа нэг улсаас нэн хамааралтай байгаа бөгөөд цаашид энэ хэвээр байж үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлсөн хэвээр байна гэдэгтэй бүхий л түвшинд санал нийлж байгаа боловч энэхүү асуудал дээр тусгайлсан бодлого боловсруулах, үр дүнтэй хэрэгжүүлэх тал дээр хангаттай бус дутмаг байна.

Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал гэдэг нь өөрийн орны экологийн өвөрмөц нөхцөлд технологи болон мэдээлэл, судалгааг улс орныхоо хөгжилд ашиглах, шинжлэх ухааны үндэсний чадамжийг дээшлүүлэх, оюуны үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг хангасан нөхцөл байдал¹⁰ юм.

Мэдээллийн аюулгүй байдал гэдэг нь төрөөс улс орны дотоод, гадаад бодит байдлыг зөв үнэлж, оновчтой шийдвэр гаргах үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллээр төрийн байгууллага, ард иргэд хангагдсан, Монгол улсын талаар гадаад мэдээлэл тархах нөхцөл хангагдсан байдлыг хэлнэ¹¹ гэж тус тус тодорхойлсон.

Бид шинжлэх ухаан технологи, мэдээллийн аюулгүй байдлын ач холбогдлыг үзэхдээ гадаад болон дотоод гэсэн хоёр хэсэгт хувааж үзвэл үр дүнтэй байна. Монгол улс өөрчлөлт шинжлэлийг хийж эхлэх үед технологийн хувьд 100 хувь хуучнаар социалист чиг баримжаатай гэгдэж тэр дундаа ЗХУ-аас (хуучнаар) хамааралтай явж ирсэн бөгөөд ЗХУ болон манай улс дотооддоо өөрчлөлт хийж

¹⁰ Мөн тэнд, 6-р зүйл

¹¹ Мөн тэнд, 7-р зүйл

эхэлсэнтэй холбоотой шилжилтийн үеийн нийгэм, эдийн засгийн хямрал, хувь хүмүүсийн сэтгэхүйд гарсан өөрчлөлт зэрэг олон хүчин зүйлээс үүдэн оюуны хөдөлмөр эрхлэгчид цөөрсөн, уг салбарт ажиллаж байгаа судлаач, эрдэмтдийн ажлын нөхцөл муу, нийгмийн хамгаалал баталгаагүй, ажлын багаж хэрэгсэл хангалтгүй нэн шаардлагатай шинжилгээг гадагш явуулж хийлгэх шаардлагатай болдог, энэ нь цаг их алддагаас зарим тохиолдолд ач холбогдлоо алдах хүртэл байдалд хүрч байна.

Монгол улсад өнөөдөр шинжлэх ухаан технологийн талаар явуулах нэгдсэн бодлого дутагдаж байна. Тухайлбал, урьд үндэсний орлогын 20 хувийг зарцуулдаг байсан бол өнөөдөр 3 хувийг зарцуулж байна. Манай улсад эрдэм шинжилгээний ажилтнуудын тоо сүүлийн 10 жилд 1.5 дахин буурч, дундаж нас 40 гарч, 30 хүртэлх насны залуу ажилтнуудын эзлэх хувийн жин 20 хувьд хүрсэн, эрдэм шинжилгээний байгууллагуудын багаж төхөөрөмжийн 50-иад хувь нь 1950-1980 онд, 30 гаруй хувь нь 1981-1990 онд, 18 хувь нь 1991 оноос хойших хугацаанд тус тус ашиглалтад орсон, эрдэмтэн судлаачид явуулж буй судалгааныхаа талаар гаднаас мэдээлэл авах, өгөх, өндөр хөгжилтэй орнуудад сурах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх боломж хомс, хангалттай бус байна.

Манай орон гадаадаас техник, технологи авч байгаа ч хөрөнгө мөнгө, иргэдийн боловсрол зэргээс шалтгаалж үр бүтээлтэй ашиглагдаж чадахгүй байна. Нөгөөтэйгүүр мэдээллийн технологи өндөр хөгжсөн өнөө үед улсын аюулгүй байдал, нууцлалтай холбогдох мэдээлэл алдагдахгүй байх боломж улам бүр багасаж энэ нь үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хэмжээнд хүрээд байна. Улс төрийн маш нууц зэрэглэлд хамаарах мэдээ, газар зүйн байр зураг, судалгаа шинжилгээтэй холбогдох материалууд хэвлэлээр цацагдах, хил, гааль дээр хураагдах, хар зах дээр дамлагдан зарагдсан нэг биш тохиолдол гарч байгаа нь өнөөдөр энэ чиглэлийн аюулгүй байдал хангагдаж чадахгүй байгааг харуулсаар байна.

Нөгөө талаар Монгол улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын талаар гадаад орнуудад бодит бус мэдээлэл тарснаас бусад улсад эргэлзээ төрөх явдал одоо ч гарсаар байна. Жишээ нь: Тайваньд үйлдвэрлэсэн дэлхийн газрын зураг дээр Монгол улсын хилийн зурвасыг тогтоогоогүй, БНХАУ нутаг дэвсгэрийн нэг хэсэг болгон дүрсэлсэн байжээ. Мөн Монгол улсыг

мэдэхгүй байх явдал бусад улс орнууд, ард түмний дунд элбэг байгаа нь өөрийн улсаа дэлхий нийтэд таниулах явдал хангалтгүй хийгдэж байгаатай холбоотой. Хэвлэлийн эрх чөлөө гэдэг нэрийн дор янз бүрийн мэдээ, мэдээллийг ямар ч зохион байгуулалт, хараа хяналтгүйгээр гадаадад болон дотоодод нэвтрүүлж, олон түмний дотор хий хоосон цуурхал тархах, сөрөг мэдээллээр цэнэглэх¹², тэр нь улс орны оршин тогтнох аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй байгааг үгүйсгэж болохгүй юм. Мөн төрийн захиргааны аль ч байгууллага мэдээллийн сангаа жинхэнэ ёсоор байгуулаагүй учраас элдэв судалгаа, дүгнэлт, төлөвлөлтийг бодитой мэдээлэл дээр тулгуурлаж хийж чаддаггүй хэвээр байна. Иргэд орлого, татвар, зээлийн талаарх наад захын мэдээлэл олоход хэцүү нөхцөлд төрөөс нийгмийг удирдах, үйлчлэх чадвар буурах байдалд хүрч байна.

Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал: Монгол түмэн, Монгол төр оршин тогтнож, хөгжихийн үндэс болсон хэл бичиг, түүх, соёл, зан заншил хадгалагдах, монгол хүн ард үүрд оршин амьдрах нөхцөл хангагдсан байдлыг хэлнэ.¹³ Монголын соёл иргэншлийн орон зайн болоод түүхэн цаг хугацааны өвөрмөц төлөв байдал нь даяаршлын нөхцөлд үндэснийхээ иргэншлийн аюулгүй байдлыг хангах олон улсын туйлын ухаалаг баталгааг бүрдүүлэхийг шаардаж байгаа билээ. Соёл иргэншил гэдэг нь үндэсний хэл бичиг, түүх, соёл, зан заншил, тухайн ард түмний ёс суртахуун, хүмүүжлийг агуулсан өргөн хүрээтэй ойлголт бөгөөд туйлын болгоомжтой хандах зүйл гэдгийг хэлэх хэрэгтэй¹⁴.

Өнөөдөр соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангах, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр “Үндсэн хууль” (1992), “Монголын төрөөс баримтлах соёлын бодлого”, “Эх хэлний тухай”(1996), “Ардын уламжлалыг хадгалах хөтөлбөр” (1999) зэрэг хууль, хөтөлбөр, баримт бичгүүдийг батлан гаргаж мөрдөж байгаа нь үр дүнгээ өгч байна. Мөн ардын авьяастнуудын бүтээлийг судлах, сурталчлах, урлагийн наадам зохиох, түүх соёлын дурсгалуудыг сэргээн засварлах, хамгаалалтад авах зэрэг олон ажлуудыг хийж үр дүнгээ өгч байна.

Дэлхийн 6 тэрбум гаруй хүн амын аравны нэг нь нүүдлийн соёлтой гэж үздэг. Гэтэл тэдгээр нүүдэлчдээс дэлхийн түүхэнд мөрөө үлдээсэн нь монголчууд

¹² Д.Лүндээжанцан. Аюулгүй байдал, хөгжил, төр эрх зүй. УБ., 2002. 87 дэх тал

¹³ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 1994. 8-р зүйл

¹⁴ Академич Б.Энхтүвшин. “Глобальчлал эрин дэхь хүний аюулгүй байдал”, ОУ-ын бага хурал УБ., 2000. 226 дахь тал

бид билээ. Монголчууд бид дэлхийг 200 гаруй жил донсолгож байсан түүхтэй ийм ул мөрөө үлдээхэд бидний нүүдлийн соёл иргэншил хамгийн гол үүргийг гүйцэтгэж байсан талаар судлаачид бичдэг. Өнөөдөр ч өөрийн орны өргөн уудам нутаг орныг эзэмших, ашиглах, соёл, өв, уламжлалаа хадгалах, өвлүүлэх зэрэг олон зүйлд нүүдлийн амьдралын хэв маяг өөрийн үүргээ гүйцэтгэсээр байна. Иймээс бидний бахархах зүйлийн нэг нь нүүдлийн амьдралын хэв маяг билээ. Гэхдээ нийгэмд гарч буй өөрчлөлт, цаг агаарын хүндрэл, бэрхшээл зэрэг олон хүчин зүйлүүдээс шалтгаалж малчид малаа орхин хот, суурин газар бараадах үзэгдэл газар авч байна. 2002 онд хийсэн судалгаагаар нийт хүн амын 57.4 хувь нь хотод, 42.6 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна.

Бидний бахархан ярьдаг нүүдлийн соёл нь малчдын амьдрал ахуйтай салшгүй холбоотой, түүний цөм нь хөдөө орон нутагт нүүдэллэн амьдарч буй малчид болж байдаг. Гэтэл зөвхөн 1995-2000 онд хөдөө орон нутгаас нийслэл хот руу 95.4 мянган хүн шилжиж ирсэн байна. Өнөөдөр ч хөдөө орон нутгаас ирэгсдийн тоо нэмэгдсээр байгаа нь алслагдсан орон нутаг эзгүйрэх, амьдралын хэв маяг алдагдах, эдийн засгийн үйлдвэрлэл гэх зэрэг олон зүйлд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй хамгийн гол нь биднийг дэлхийн бусад улсуудаас ялгаж өгч байдаг нүүдлийн соёл иргэншлийн аюулгүй байдалд шууд бус гэхэд дам нөлөөлөх түвшинд хүрээд байна.

Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал: Монгол улсын хүн амын эрүүл мэнд, удмын сан, тогтвортой өсөлт хадгалагдаж, хамгаалагдсан нөхцөл байдлыг хэлнэ.¹⁵

Монгол орны хувьд анхаарлын төв хүн ам, удмын сангийн асуудалд зайлшгүй орно. Зайлшгүй оруулах болсон шалтгаан, нөхцлийг гадаад, дотоод нөхцлийн талаар хэд хэдэн хүчин зүйлийг хэлж болно. Үүнд:

1. Дотоод хүчин зүйлд:

- Хүн ам цөөн;
- Газар нутаг өргөн;
- Төрөлт буурсан;
- Баталгаагүй хүнс, барааны хэрэглээ;
- Ургийн бичиг хөтлөлт, овог удмаа мэдэхгүй байх зэрэг юм.

¹⁵ Мөн тэнд, 226 дахь тал

2. Гадаад хүчин зүйлд:

- Даяаршилд өргөн хамрагдах болсон (дэлхий нийттэй нээлттэй харилцах болсон);
- Газар зүйн байрлал (Хятад 1.288 тэрбум хүн амтай, 1км² газар нутагт оногдох хүн ам 138, ОХУ 143 сая хүн амтай, 1 км² газар нутагт оногдох хүн ам 8);
- Баталгаагүй хүнс, барааны хэрэглээ;
- Соёлын болон дадал зуршлын сөрөг хандлага ;
- Гадаад иргэдийн шилжилт, хөдөлгөөн зэрэг нь хүн ам, удмын сангийн аюулгүй байдалд шууд нөлөөлж байна.

Алслагдсан орон нутгийн иргэд удаан жил амьдарч ирсэн иргэдийн үр сад хоорондоо суух явдал байсаар, залуус ихээр гадаадад гарч ажиллаж, сурч байгаа нь сайн ч иргэж эх орондоо ирэх нь бага, тухайн орны иргэдтэй гэр бүл болох, тухайн орноос нийгмийн сөрөг үзэгдлүүдийг авчрах (мансуурах, ХДХВ/ДОХ гэх мэт), гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэх нь сайн зүйл ч түүнийг дагаад гадаад иргэд олноор ирж хууль бусаар амьдрах, иргэдтэй гэр бүл болох, тэднийг харж хянах ажил хийгдэхгүй орхигдох, ашиг харж баталгаагүй, чанаргүй хүнс, бараа гадаад орноос ихээр оруулах зэрэг олон хүчин зүйлийг тэмдэглэж болно.

Даяаршилд суралцах, зах зээлд шилжих явцад олон сөрөг үзэгдэл нийгэмд гарч байгаагийн дотор айл өрхийн аж төрөх ёс, уламжлалт ёс, хүний мөс эвдэрч байгаа нь хүүхдээ хаях, биеэ үнэлэх, архидах, гэмт хэргийн олон жишээнээс харагдаж байна. Доктор Ц.Мухар “10-15 жилийн өмнө Монголд жил бүр 80 мянган хүүхэд төрдөг байсан, одоо 50 мянга болжээ” гэжээ. Монголд хүн, амьтны гоц халдварт өвчин ялангуяа тарваган тахал, шүлхий өвчин зэрэг нь элбэг байдаг. Сүүлийн үед дэлхий нийтийн сэтгэл эмзэглүүлж буй гоц халдварт өвчин ХДХВ/ДОХ Монголд орж ирсэн явдал хоёр сая гаруй хүн амтай Монгол улсын хувьд нэн яаралтай арга хэмжээ авбал зохих асуудлуудын нэг болоод байна. Мөн Монгол улсад цус ойртох үзэгдэл элбэгшиж байгаа бөгөөд ялангуяа говийн аймгуудаар энэ үзэгдэл өргөн тархжээ. Архидан согтуурах явдал газар авч байгаа нь бас сэтгэл эмзэглүүлж байна. Монгол улсын хүн амд ноогдох спиртийн хэмжээ бусад орнуудыг бодвол 5-8 литрээр илүү байдаг. Статистик мэдээнээс үзвэл

улсын хэмжээнд бүртгэгдсэн 5 гэмт хэрэг тутмын 1 нь буюу нийт гэмт хэргийн 22.8 хувь нь согтуугаар үйлдэгдсэн байна.

Архидан согтууралт, гэр бүл салалтын статистик үзүүлэлтийн цаана үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлөх олон янзын шалтаг, шалтгаан оршсоор байна. Эмэгтэйчүүдийн боловсрол давамгайлж, “архинд толгойгоо мэдүүлэгсэд олширч байгаа нь гэр бүл төлөвлөлтөд сөргөөр нөлөөлж байна. Эмэгтэйчүүд нь боловсролоороо (эзэмшдэгээрээ) Гиннесийн номонд орж эхний 10 улсын тоонд багтаж байгаа нь сайшаалтай боловч боловсролтой эмэгтэйчүүд (оюутны 70 хувь) ажилгүй буюу хар захын наймаачин эрчүүдийг нөхрийн хувьд хүндэтгэж харах уу, гэр бүл тогтвортой байна уу зэрэг олон асуудал гарч ирж байна. Гэтэл хөрш оронд маань “нэг гэр бүл-нэг хүүхэд” бодлогын дүнд эрчүүд зонхилох боллоо. Даяаршлын үед энэ нь буурай орны хувьд үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх байдалтай болж байна. Мөн монголчууд гадаадад ихээр гарч ажиллах, харийн хүнтэй гэр бүл болох асуудал жилээс жилд өргөжиж байгааг бодолцох ёстой.

Экологийн аюулгүй байдал: Байгаль цаг уурын өөрчлөлт болон байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах бодлогын харьцаа алдагдсанаас хүний амьдрах орчин, эдийн засагт үүсэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх нөхцөл хангагдсан байдлыг хэлнэ.¹⁶

Нүүдлийн соёл иргэншлийн ачаар унаган байгальтайгаа үлдсэн Монгол улсын хувьд байгалийн баялаг руугаа хэт хандсан үйлдвэрлэл явуулсан сүүлийн жилүүдэд экологийн тэнцвэр алдагдах агаарын бохирдол нэмэгдэх, цөлжих процесс эрчимжих үүд хаалгыг нээж байна. Ялангуяа агаарын бохирдол Улаанбаатарт асар их байгаа нь тоо нь гагцхүү энэхүү асар ихээр нэмэгдсэн технологийн шаардлага хангасан, хангаагүй машин элбэгшсэнээс үүдэлтэй юм. Мөн гэр хорооллын айлуудын утаа ч илт нөлөөлж байна. БОЯ-ны мэргэжилтний үзэж байгаагаар Улаанбаатар хотын агаарын бохирдол сүүлийн 10 жилд 5 дахин нэмэгдсэн байна.

Даяаршлын эрин дэх улс үндэстний эрх ашиг улсын хилээр хязгаарлагдахаа больж байгаагийн нэг жишээ бол байгаль орчны асуудал юм. Ган, дулааралт, цөлжилт зэрэг асуудал зөвхөн нэг улс орны хүрээнд шийдвэрлэх асуудал биш, улс орон, иргэн бүрийн санаа зовох асуудал болоод байна. Өнөөдөр

¹⁶Мөн тэнд, 10-р зүйл

Сөүл хотын агаар бохир байгаа нь Монголын тоос шорооноос боллоо гэх болжээ. Өвөр Монголын тал нутагт суурин иргэд олноор суурьшин газар тариалан эрхлэн, уул уурхай олширч, хотын хойд хэсэг ялангуяа Бээжингийн экологийн тэнцвэрийг алдагдуулсан хэрэг төдийгүй Солонгос, Япон, АНУ-г түгшээх болсноос харагдаж байна.

АНУ-ын ТТГ-ын сүүлийн үеийн судалгаагаар ирээдүйн дайн, зэвсэгт мөргөлдөөн газар нутгийн гэхээсээ илүү усны асуудлаас болох төлөвтэй гэсэн дүгнэлт гаргасан бөгөөд иймэрхүү асуудал Ойрхи Дорнодод хурц асуудал болж БНХАУ-ын хойт нутгуудад усны асуудал ойрын ирээдүйд маш хурцаар тавигдаж улмаар аюулгүй байдалтай ч холбоотой болж болзошгүйг тайландаа дурьдсан байдгийг манай улс ихээхэн анхааран судлах асуудлын нэг мөн. Монгол улс байгаль орчноо хамгаалж, экологийн асуудлаа зохистой шийдвэрлэж чадвал ирээдүйн үндсэн баялаг, дэлхийн даяаршилд оруулах манай гол хувь нэмэр, үндэсний аюулгүй байдлаа баталгаажуулах чухал хэрэгсэл байж болох талтай.

Эдгээр асуудлуудыг анхаарч тодорхой арга хэмжээ нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Дээрх байдлаас харахад Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад олон шийдвэрлэвэл зохих асуудлууд хуримтлагдаад байна.

Ашигласан материал

1. Г.Батаа, С.Галсанжамц. Монгол Улсын аюулгүй байдал /Орос Монголын судлаачдын үзэл бодол/ УБ.1999
2. Ж.Бор. Монголын тусгаар тогтнолын гэрэл сүүдэр УБ.1996
3. О.Билэгбат. Төв азийн аюулгүй байдал ба Монгол улс УБ. 2003
4. Д.Баярхүү. Евразийн геополитик, олон улсын харилцаа /одоо ба ирээдүй/ УБ.2002
5. С.Дашцэвэл. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба гуравдах түнш орнууд УБ.2002
6. Д.Далайжаргал. Олон улсын терроризм ба Монгол улсын үндэсний аюулгүй байдал УБ.1999
7. М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон улсын эрх зүй УБ.1999
8. М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс
9. Дорно дахин судлалын хүрээлэн 1990-ээд оны олон улсын харилцааны хандлагууд, Монгол Улс- Их гүрнүүдийн харилцаа
10. Д.Лүндээжанцан. Аюулгүй байдал, хөгжил, төр эрх зүй УБ 2002
11. Д.Лүндээжанцан. Үндсэн хуулийн эрх зүй УБ 2000
12. Н.Лүндэндорж. Төрийн онол УБ.1997
13. Монгол Улсын төрийн үзэл баримтлал, бодлого чиглэл УБ.2002
14. Найдансүрэн, Д.Содномгомбо. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал түүнийг хангах зарим асуудал УБ.2000
15. Ц.Сарантуяа. Төрийн ерөнхий онол. УБ.1999
16. Т.Сэнгэдорж. Хуульчийн мэргэжил УБ.2000
17. Т.Сэнгэдорж. Монгол Улсын төр, эрх зүйн үндэс. УБ.2000.
18. Т.Сэнгэдорж.Хуулийн шинжлэх ухааны судалгааны арга зүй. УБ.2001
19. Я.Чимгээ. Ази-Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын тогтолцоо: Монгол улсын хувь нэмэр УБ.2003
20. Д.Чулуунжав. Монголын төрийн тогтолцоо, түүний хууль эрхийн үндэсүүд дэхь дутагдал, согог, асуудлууд /1990-1999/. УБ.1999

21. Р.Болд, Б.Ганбаатар. Эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал. УБ.2002
22. "Глобальчлалын Эрин дэх Хүний Аюулгүй Байдал". /Олон Улсын бага хурал/ УБ.2000
23. "Глобальчлал, Монгол Улсын хөгжил". /Эрдэм шинжилгээний бага хурал/ УБ.2002
24. "Хүний эрх ба Үндэсний аюулгүй байдал". /Олон улсын симпозиум/ УБ. 1998
25. Хууль, Үзэл баримтлал, баримт бичгүүд:
26. Үндсэн хууль /1992/
27. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал /1994/
28. Гадаад бодлогын үзэл баримтлал /1994/
29. Монгол улсын төрийн цэргийн бодлогын үндэс/1998/
30. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль /2001/
31. Цөмийн зэвсэгээс ангид байх тухай хууль /2000/
32. Батлан хамгаалах цагаан ном /2001/
33. Монгол улсын төрөөс баримтлах хүн амын бодлого /1996/
34. Гадаад бодлогын хөх ном /2000/
35. 1. www.Gate1.pmis.gov.mn /Ерөнхийлөгч/
36. 2. www.Pmis.gov.mn/nsc/ /Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл/
37. 3. www.Pmis.Gov.mn /Монгол Улсын Засгийн Газар/
38. 4. www.Eximin.mn /Гадаад Хэргийн Яам/
39. 5. www.Monjustice.mn /Хууль Зүй Дотоод Хэргийн Яам/
40. 6. www.Pmis.gov.mn/mdef/ /Батлан Хамгаалах Яам/
41. Зууны мэдээ сонин
42. Стратеги судлал сэтгүүл /1999 №2, 2001 №1-2/
43. Олон улсын харилцаа сэтгүүл /2001 №1, 2002 №1-2/
44. Дорно Өрнө сэтгүүл /1996 №2, 1999 №2-3/